



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 12 өдөр

Дугаар A/183

Бат-Өлзий сум

Г Цэрэг татлагын ажлыг зохион байгуулах  
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дах хэсэг, Засгийн газрын "Журам батлах тухай" 2017 оны 144 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын "Цэргийн жинхэнэ албаны халалт, татлагыг зохион байгуулах тухай" 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн A/717 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 оны ээлжит цэрэг татлагын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Дарга: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)  
Гишүүд: Б.Ганням (Эрүүл мэндийн төвийн дарга)


Э.Мөнхбаяр (Соёлын төвийн дарга)  
Д.Энх-Амгалан (Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн хошууч)  
Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)  
Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)  
С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)  
Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)  
Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)  
Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)  
Г.Доржханд (Хууль, эрх зүйн мэргэжилтэн)  
Г.Цэрэндулам (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)  
Б.Уганцэцэг (Нийгмийн даатгалын улсын байцаагч)  
Б.Орбиш (Архив, бичиг хэргийн эрхлэгч)  
Г.Хулан (Засаг даргын Тамгын газрын нийгмийн ажилтан)  
Ц.Баасанжав (Насан туршийн боловсролын нэгжийн багш-арга  
зүйч)  
Ц.Маргад-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын нярав)

2. Сумын цэрэг татлагын ажлын хэсгийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Цэргийн жинхэнэ албанад татагдаж буй иргэдэд эрүүл мэндийн үзлэг явуулах эмч, мэргэжилтнүүдийг ажиллуулах, шаардлагатай тоног төхөөрөмжийг бэлэн байлгах, цэрэг татлагын үйл ажиллагааны үеэр ариутгал, халдвартайжүүлэлтийн горимыг чанд сахиж, Эрүүл мэндийн төвөөс мэргэжлийн албан тушаалтуудыг томилж ажиллуулахыг Эрүүл мэндийн төвийн дарга

(Б.Ганням)-д, цэрэг татлага явуулах байр бэлтгэхийг Соёлын төвийн дарга (Э.Мөнхбаяр) нарт тус тус үүрэг болгосугай..

4. Цэрэг татлагын үеэр нийгмийн хэв журмыг хамгаалах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга (Цагдаагийн хошууч Д.Энх-Амгалан)-д үүрэг болгосугай.



Сумын Засаг даргын 2024 оны 09 дүгээр  
сарын 17-ны өдрийн А/183 дугаар  
захирамжийн хавсралт

**БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЦЭРЭГ ТАТЛАГЫН  
АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ**

№	Хийж гүйцэтгэх ажил	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Aжлын хуваарь танилцуулсан байдал
				1 2 3 4
1.	Цэрэг татлагын ажлын хэсэг хуралдах		ЗДТГ-ын дарга	
2.	Цэрэг татлагын ажилд шаардагдах хөрөнгийг сумын ИТХ-аар батлуулан шийдвэрлүүлсэн байна		ЗДТГ-ын дарга	
3.	Эрүүл мэндийн төв, багийн эмч наортайгаа хамтран эрүүлжүүлэх боломжтой 18-25 насны залуучуудыг уэрэг татлагаас өмнө эмчийн үзлэгт хамруулан суманд эмчлэх боломжтойг нь эмчлэн эрүүлжүүлж, цэргийн албанад тэнцүүлэх арга хэмжээг авна		ЗДТГ-ын дарга, Эрүүл мэндийн төвийн дарга, Багийн Засаг дарга нар	
4.	Цэрэг татлагын комиссын бэлтгэл ажлыг хэрхэн хангаж ажилласан талаар мөн дайчилгааны бэлэн байдлын талаар танилцуулга сонсох 5-10 минутын танилцуулгыг компьютерийн үйлдлийн системийн PowerPoint программ дээр бэлтгэх		ЗДТГ-ын дарга	
5.	Цэрэг татлагын үеэр ариутгал, халдвартгүйжүүлэлтийн горимыг сахиж, цэрэг татлагын байранд Эрүүл мэндийн төв өдөрт 2 удаа ариутгал халдвартгүйжүүлэлт хийж, нэг дор 20-оос дээш цэрэгт татагдагч иргэн цуглахгүйгээр цагийн нарийвчлалтайгаар эрүүл мэндийн үзлнгт оруулна.		Эрүүл мэндийн төв, Багийн засаг дарга гар	
6.	Цэрэг татлагын комисст амны хаалт болон гар ариутгагчаар бүрэн хангах		ЗДТГ-ын дарга	
7.	Цэрэгт татагдагчдын нэrsийн бүртгэлийг 18-25 насны болон 1999-2006 онд төrsөн иргэдийн овог нэр, регистрийн дугаарыг Цэргийн штабын excel программ дээр боловсруулан үйлдлийн системын дагуу нэг бүрчлэн бичиж оруулан бэлэн болгох		Багийн Засаг дарга нар, Архив, бичиг хэргийн эрхлэгч	
8.	Зарлан дуудах мэдэгдлийг цэрэгт татагдагч иргэн бүрт гардуулан өгч, хүлээн авсан этгээдээр гарын үсэг зуруулж, буцаах тасалбараар Засаг даргын Тамгын газрын даргатай тооуoo хийсэн байна.		Засаг даргын Тамгын газрын дарга, Багийн Засаг дарга нар	

9.	Цэрэгт татагдагч иргэн бүр иргэний үнэмлэх, цэргийн үүрэгтний үнэмлэх, өвчлөл бүхий иргэд картаа заавал авч ирсэн байх, ар гэрийн гачигдлын учир чөлөөлүүлэхийг хүссэн иргэд багийн Засаг даргын тодорхойлолт, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж, сумын цэрэг татлагын товчоогоор нэг бүрчлэн хэлэлцүүлж зохих журмын дагуу шийдвэрлэсэн байна.		Засаг даргын Тамгын газрын дарга, Багийн Засаг дарга нар, Нийгмийн даатгалын улсын байцаагч	
10.	Цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэг явуулах байрыг дулаан, гэрэлтүүлэг сайтай байлгах, хивс, дрож дэвссэн, агааржуулалтын шаардлага ханганд ажиллах нөхцөл боломжоор бүрэн хангах		Э.Мөнхбаяр Б.Ганням	
11.	Цэрэгт татагдагчдын анкетыг шинэчлэгдсэн загвараар нээж 2 хувь үнэн зөв комьютерээр бичиж, зураг наан, ам булийн талаар шинэчлэн тодотгож дэлгэрэнгүй бичих		Багийн Засаг дарга нар	
12.	цэрэг татлагаар их, дээд сургуулиудын 1, 4 дүгээр дамжааны оюутнуудыг дуудахгүйгээр бусад оюутан сурагчдыг "Цэргийн албаны тухай" хуулийн дагуу цэрэг татлагад бүрэн хамруулах учир оюутан, сурагчид цэрэг татлагад ирэхдээ сургуулийн тодорхойлолт, төлбөр төлсөн баримтыг үндэслэн цэрэгт татах эсэх талаар шийдвэр гаргана.		Багийн Засаг дарга нар	
13.	Засгийн газрын 2021 оны 41, 2022 оны 120 дугаар тогтоолуудын дагуу 1997, 1998 оны цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол хангасан иргэдэд мөнгөн төлбөр тогтоох, мөнгөн төлбөрийг барагдуулахад иргэдийг бэлэн байлгах		Багийн Засаг дарга нар Г.Доржханд	
14.	Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж буй иргэдийг холбогдох бичиг баримтын хамт бэлэн байлгах, ажлын үр дүнг хүн нэг бүрээр тооцох		Засаг даргын Тамгын газрын дарга, Багийн Засаг дарга нар	
15.	Цэрэг татлагын комиссоор орох бүх иргэдэд цэргийн үүрэгтний үнэмлэх бүрэн олгогдсон байх		Засаг даргын Тамгын газрын дарга, Ц.Баасанжав	
16.	Зарлан дуудах хуудастай хамт бөглөсөн мэдэгдэх хуудсыг бэлэн байлгах, 2024 онд 18-25 насны бүх иргэдэд зарлан дуудах мэдэгдэл хүргүүлэх (сараар 18 насанд хүрээгүй иргэнд зарлан дуудах хуудас хүргүүлээгүй гэсэн асуудал гаргахгүй байх)		Багийн Засаг дарга нар	